ТАНИЛЦУУЛГА

2022 оны 1 дүгээр улиралд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

"Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" хууль, "Иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолын хүрээнд яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон орон нутгийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд 2022 оны 1 дүгээр улиралд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг нэгтгэн танилцуулж байна.

2022 оны 1 дүгээр улиралд **118198** иргэнээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдол, санал хүсэлт гаргасан байна.

Үүнээс **110089** иргэний өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, **424** иргэний өргөдлийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэжээ. Шийдвэрлэлт **93.1** хувийн үзүүлэлттэй байна. Мөн **2634** өргөдлийг холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн шийдвэрлүүлжээ.

Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл гомдолд санхүүгийн дэмжлэг хүссэн, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах хүсэлт өндөр үзүүлэлттэй байлаа.

Тайлант хугацаанд **19947** иргэн нийгмийн халамж, үйлчилгээнд хамрагдах, санхүүгийн дэмжлэг хүссэн**, 13014** иргэн хөдөлмөр эрхлэлт, ажилтай, орлоготой болоход дэмжлэг хүссэн өргөдөл гаргасан байна.

Цаашид өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн чанарыг сайжруулах, явц байдлыг ил тод нээлттэй болгох, тайлан мэдээг цахимжуулах зорилгоор Unelgee.gov.mn цахим хуудаст өргөдөл гомдлын тайлан мэдээг нэгтгэх бэлтгэл ажил хийгдэж байна.

Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах-1111 төвд хандаж гаргасан иргэдийн санал хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлыг 2022 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр Засгийн газрын 25 дугаар хуралдаанд танилцуулсан тул тайлан мэдээнд нэгтгээгүй болно.

Нэг. Засгийн газрын гишүүд, яам, агентлагийн удирдлагад хандаж иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын талаар:

2022 оны 1 дүгээр улиралд Засгийн газрын гишүүд болон яам, агентлагийн удирдлагад хандан иргэдээс нийт **50852** өргөдөл, гомдол гаргаснаас **47335** өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн нь **93.0%**-ийн үзүүлэлттэй байна. *(өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг хүснэгт №1-т харуулав)*

23113 иргэн бичгээр, **11878** иргэн цахимаар, **13420** иргэн утсаар, **2110** иргэн биечлэн ирж уулзаж өргөдөл, гомдол, санал хүсэлтээ гаргажээ.
(Өргөдөл, гомдлыг хэлбэрээр нь ангилан хүснэгт №2-т харуулав)

Хоёр. Нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын талаар

2022 оны 1 дүгээр улиралд аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж нийт **67346** иргэн өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснээс **62754** өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн нь **93.2%-**ийн үзүүлэлттэй байна. (*Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдлыг нэгтгэн хүснэгт №3-т харуулав)*

Нийт өргөдөл, гомдол, санал хүсэлтийн **45940** бичгээр, **7358** цахим хэлбэрээр, **10342** нь утсаар, **3298** иргэн биечлэн ирж санал хүсэлтээ илэрхийлжээ.
*(Өргөдөл, гомдлыг хэлбэрээр нь ангилан хүснэгт №4-**т** харуулав)*

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн даатгал, халамж үйлчилгээнд хамрагдах, орон сууц, санхүүгийн дэмжлэг хүссэн, газрын харилцаатай холбоотой асуудлууд хандалт өндөртэй байлаа.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР